

Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах үйл ажиллагааны эрх зүйн орчин

Дугарсүрэнгийн Отгонсүрэн^{1,*}

Лувсандондивийн Оюунцэцэг²

¹ Чойжин ламын сүм музей, Улаанбаатар, Монгол Улс

² Шинжлэх ухаан технологийн их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

¹ ORCID: <https://orcid.org/0009-0006-6084-4119>

* Холбоо барих зохиогч: templemuseum1@gmail.com

Хураангуй: Түүх соёлын дурсгалт зүйлс нь улс орны үндэсний өвөрмөц онцлогийн илэрхийлэл, тусгаар тогтнолыг батлах хөдөлшгүй нэг баримт болдог тул тэдгээрийг хайрлан хамгаалах, сэргээн завсарлах, хойч үедээ уламжлан өвлүүлэх нь төр засгийн бодлогын чухал зорилт болж ирсэн. Монгол Улс анхны үндсэн хуулиа баталж, тусгаар тогтнолоо тунхагласан 1924 онд соёлын өвийг сэргээн засварлахтай холбоотой харилцааг зохицуулах “Хуучин зүйлийг сахин хамгаалах дүрэм”-ийг баталсан байдаг нь тохиолдлын зүйл биш юм. Энэ үеэс салбарын хууль эрх зүйн орчин бүрдэх үйл авц эхэлсэн бөгөөд 1970 онд “Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль” батлагдаж, 1973 онд Соёлын яамны харьяанд Түүх, соёлын дурсгалт зүйлийн засварын газар байгуулагджээ. Өнөөгийн байдлаар салбарын хууль эрх зүйн орчин харьцангуй сайн бүрдээд байгаа боловч соёлын дурсгалт зүйлс, барилга байгууламжийг сэргээн засварлах ажил үйлчилгээний одоогийн практик, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэд тулгарч буй шийдвэрлэвэл зохих цөөнгүй асуудлууд байсаар байна.

Энэхүү өгүүллэгт соёлын дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах үйл ажиллагааны хууль эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн байдлыг судалсан зарим үр дүнг тусган авч үзсэн болно.

Түлхүүр үгс: архитектурын өв, сэргээн засварлалт, хууль эрх зүйн зохицуулалт, эзэмшигч болон өмчлөгчийн эрх, үүрэг

Legal conditions for renovation works of cultural heritage structures

Otgonsuren Dugarsuren^{1,*}
Oyuntsetseg Luvsandongiv²

¹ Chojjin Lama Temple Museum, Ulaanbaatar, Mongolia

² Mongolian University of Science and Technology, Ulaanbaatar, Mongolia

¹ ORCID: <https://orcid.org/0009-0006-6084-4119>

* Corresponding author: templemuseum1@gmail.com

Abstract: Preservation, protection, renovation of the historical and cultural heritage items, and furthermore, transmitting them to our later generations in intact is regarded as a priority in the government policies as far as they stand as material monuments of specific characteristics of the nation and its independence. It was not a mere incident that Mongolian government had enacted the Preservation and Protection of Old Items Rules in 1924 right after promulgation of the first Mongolian Constitution as an independent State. Later in 1970, ‘Cultural Monument Protection Law’ was adopted, and then Historical and Cultural Monument Item Renovation Agency was established in 1973 under the Ministry of Culture. Although laws and regulations related with cultural heritage, which are in force today, are comparatively adequate, there are still numerous problems to be solved in their implementations, and particularly in practices of renovation works, preservation and protection of cultural heritage items and constructions.

This article deals with some research outcomes on laws and regulations related with renovations of historical and cultural monument structures, and their implementations.

Keywords: *architectural monuments, renovation works, legal conditions, rights and responsibilities of legal owners and proprietors.*

Оршил

Монголчууд нүүдлийн өвөрмөц соёл иргэншилтэй, түүндээ зохицсон соёл, урлаг, зан заншил нэвт шингэсэн арвин баялаг түүх, соёлын өвийг бүтээсээр ирсэн билээ. Монголын ард түмний олон зуун жилийн туршид бүтээж, уламжлуулж ирсэн түүх соёлын өвийг зохих журмын дагуу эх төрх, шинжээр нь сэргээн засварлаж, хадгалан хамгаалж, хойч үедээ үлдээх нь манай улсын дэлхий дахины өмнө хүлээсэн үүрэг юм. Монгол Улсын “Үндсэн хууль”-д (1992) “Монголын ард түмэн бид улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн тунхагласан ба 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасан.

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламж нь анх барьж байгуулсан унаган газар, хүрээлэх орчиндоо үнэ цэн, ач холбогдол нь илэрхийлэгдэхийн хамт хууль

эрх зүйн хамгаалалтад тухайлан авсан байдаг үл хөдлөх хөрөнгө юм. Түүх, соёлын дурсгалт барилга нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх, соёл, урлаг, шинжлэх ухааны үнэ цэн, ач холбогдол бүхий биетээр оршин байгаа соёлын өв тул түүнийг сэргээн засварлах үйл ажиллагаа нь хууль эрх зүйн зохицуулалттай байж ирсэн байдаг.

Иймээс түүх соёлын өв, нэн ялангуяа дурсгалт барилгын сэргээн засварлалтын хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд тулгарч буй асуудлуудыг судалж, шийдвэрлэх шаардлагатай байна.

Судалгааны арга зүй

Ажилд баримт бичгийн судалгааны арга¹, агуулгын шинжилгээний арга², харьцуулалтын зэрэг чанарын судалгааны аргуудыг ашигласан. Судалгаанд Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, сэргээн засварлахтай холбоотой хууль тогтоомжуудыг хамруулсан.

Судалгааны үр дүн

Түүх соёлын дурсгалт зүйлсийн сэргээн засварлалтын түүхэн тойм

Манай оронд түүх соёлын дурсгалт зүйлсийг тогтоох, хадгалж, хамгаалах үйл ажиллагааны эхлэл 1924 оноос тавигдсан гэж үзэж болно. Анхны эрх зүйн баримт бичиг болох “Хуучин зүйлийг сахин хамгаалах дүрэм”-д “Монгол Улсын хязгаар дотор буй хуучны дурсгал болох зүйл цөм Монгол Улсын өөрийн хөрөнгө болох, хуучны дурсгал гэж эх түүхэнд холбогдох ямар зүйлийг хэлэхийг тодорхойлон, газрын дээр буюу доороос археологийн дурсгалт зүйлийг ухаж авах, судлан шинжлэх явдлыг Судар бичгийн хүрээлэнгээс удирдаж, харгалзан хянах, зөвшөөрөл олгох, энэ дүрмийг зөрчигч буй аваас шүүх цаазын зохих зүйлийн ёсоор яллан шийтгэж байх”-аар заасан байна. 1941 онд дээрх дүрмийг шинэчлэн баталсан ба эртний хот балгас, хэрмийн үлдэгдэл зэрэг 15 дурсгалыг улсын нэгдүгээр зэргийн хамгаалалтад, бичигт хөшөө, сүм хийд зэрэг 16 дурсгалыг бүртгэж, улсын хамгаалалтад авсан байна.³ 1944 онд Эрдэнэ зуу, Амарбаясгалант зэрэг уран барилгын дурсгалуудыг улсын хамгаалалтад авч, сэргээн засварлах ажлыг эхлүүлжээ (Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл 2021).

1970 онд “БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах хууль” батлагдсан ба энэ нь түүх, соёлын дурсгалт зүйлийг нэр төрлөөр нь ангилан, тэдгээрийг хамгаалах, ашиглах, судлан шинжлэх, сурталчлах, өвлөн эзэмших зэрэг харилцааг зохицуулсан анхны бие даасан эрх зүйн баримт бичиг болсон юм. Энэ үеэс түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах, судалж шинжлэх, сурталчлах болон

¹ document analysis method

² content analysis method

³ Уг дүрэмд “Монгол улсын хязгаар дотор буй хуучны бүх дурсгал болох зүйл цөм Монгол Улсын өөрийн хөрөнгө мөн” хэмээн заасан байдаг. Энэхүү дүрмийн ихэнх зүйл заалт нь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалахад чиглэсэн байдаг. Тус дүрэмд Улсын нэгдүгээр зэрэгт орох түүх, соёлын дурсгалуудыг анхлан бүртгэн жагсаалт гаргасан байна. Энэ жагсаалт бол Монгол Улс анх удаа түүх, соёлын үл хөдлөх дурсгалаа төрийн хамгаалалтад авсан түүхэн шийдвэр байсан юм.

тэдгээрийг засаж сэлбэх, сэргээн засварлах үйл ажиллагаа төрийн бодлогын түвшинд тавигдах болсон байна.

1973 онд Соёлын яамны харьяа Түүх, соёлын дурсгалт зүйлийн засварын газар байгуулагдсан бөгөөд 1975 онд Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор дээрх байгууллагыг Түүхийн дурсгалт барилгын зургийн групптэй нэгтгэж, “Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлдвэр-шинжилгээний товчоо” болгон зохион байгуулсан ба 1976 онд Барилга-Архитектурын комиссын харьяа “Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах газар” болгон зохион байгуулжээ. Энэ үеэс түүх, архитектурын дурсгалт барилгуудыг төлөвлөгөөтэйгөөр сэргээн засварлах ажил эхэлсэн бөгөөд тус газар нь түүх, архитектурын дурсгалт барилгын сэргээн засварлах зураг төслийг боловсруулан Алтанбулаг хот дахь Сүхбаатарын штабын байшин, Булган аймаг дахь Баруун замын байлдааны штаб, Хатанбаатар Магсаржавын байшин, Хархорин дахь Эрдэнэ зуугийн цогцолбор, Архангай аймаг дахь Заяын хүрээний дурсгалт барилгууд, Сэлэнгэ аймаг дахь Амарбаясгалант хийдийн цогцолбор, Улаанбаатар хот дахь Чойжин ламын сүм музей, Богд хааны ордон музей, Гандантэгчэнлин хийд зэрэг 40 гаруй түүх, архитектурын дурсгалт барилгыг сэргээн засварласан байна (Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр 1998).

1990-ээд оноос улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих хүнд үе эхэлснээр манай орны түүх соёлын дурсгалт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, булш хиргисүүрийг дур мэдэн ухаж тонох, ард иргэдийн өмчлөлд байсан өвөг дээдсээс уламжлагдаж ирсэн дурсгалт зүйлсээ зарж борлуулах зэрэг зохисгүй хэрэг зөрчлүүд гарах болжээ. Гэсэн хэдий ч түүх, соёлын дурсгалыг хамгаалах, эрэн сурвалжлах, судлах, сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд томоохон алхмууд хийгдсэн байна. Тухайлбал, “Монгол Улсын Үндсэн хууль” (1992), “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” (1994), “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал” (1994), “Монгол Улсын Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль” (1994), “Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого” (1996) тус тус батлагдсан (Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем).

1994 онд батлагдсан “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-д соёлын биет бус өв буюу утга соёлын өвийг өвлүүлэн уламжлуулах, хөгжүүлэх, судлах, сурталчлах харилцааг зохицуулах асуудлыг шинээр нэмж, 2001 онд “Соёлын өвийг хамгаалах тухай” цогц хуультай болсон. Мөн Монгол Улсын Иргэний болон Эрүүгийн хууль, Гаалийн хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Соёлын тухай хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль зэрэг эрх зүйн бусад баримт бичгүүдэд түүх, соёлын дурсгалыг хамгаалах, ашиглах, тэдгээртэй холбоотой аливаа хэрэг зөрчилтэй тэмцэх зэрэг урьд өмнө нь зохицуулалтгүй байсан олон заалтыг шинээр тусгажээ.

Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн хувьд -30-аас +30 хүртэлх хэмийн хэлбэлзэл бүхий эрс тэс уур амьсгал, нар, салхи, цас, бороо, ус чийг, аянга цахилгаан гэх зэрэг байгаль цаг уурын үзэгдэл, хүчин зүйлсийн байнгын нөлөөлөлд оршихоос гадна, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй тоос шороо, утаа, хог хаягдал, түүнчлэн мал амьтны өтөг, сангас зэрэгт нэрвэгдсэний улмаас гандах,

өгөрч гэмтэх, хагарч бутрах, хуурч унах, үйрэх зэргээр анхны хэлбэр, төрхөө алдаж, хийц, загвар, чимэглэл, зураглалд гэм согог учирдаг тул үе шаттайгаар сэргээн засварлах шаардлага тулгардаг.

Тийм ч учраас сүүлийн үеийн хуулиуд, тодруулбал, “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль” (1994), “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” (2001), “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” (2014) зэрэгт хуулиар хамгаалахаар зорьж байгаа харилцаа, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнгийн хэсэгт “сэргээн засварлах” талаар тухайлан тусгасан нь энэхүү үйл ажиллагаа ихээхэн чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Түүх, соёлын дурсгалт барилгын сэргээн засварлалтын ажлыг судалгаа шинжилгээний үндсэн дээр тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн нарийн мэдлэг, өндөр ур чадвартай боловсон хүчин бүхий байгууллага гүйцэтгэх талаар хууль, эрх зүйн баримт бичигт тусгасан байдаг. Иймээс дурсгалт барилгын сэргээн засварлалтыг энгийн барилга, орон сууцны адилаар хийх боломжгүй юм.

Өмнө дурдсанчлан, 1973 онд соёлын өвийг сэргээн засварлах мэргэжлийн байгууллага байгуулагдаж, Амарбаясгалант, Эрдэнэзуу, Гандантэгчэнлин, Заяын хүрээ, Цэцэн хааны ордон, Алтанбулаг дахь түүхт барилгууд зэрэг 40-өөд түүх, соёлын дурсгалт барилга, цогцолборуудыг сэргээн засварласан бөгөөд дээрх түүх, соёлын дурсгалуудыг сэргээн засварлахад төрөөс жил бүр зохих хэмжээний хөрөнгө гарган санхүүжүүлж иржээ” (Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр 1998).

Түүх соёлын дурсгалт барилгын сэргээн засварлалтын эрх зүйн зохицуулалт

Өнөөдрийн байдлаар Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн нийт 13 зүйлд 31 удаагийн нэмэлт өөрчлөлт хийснээс дурсгалт барилгыг сэргээн засварлахтай шууд хамааралтай “захиргааны байгууллагын бүрэн эрх”, “соёлын өвийн бүртгэл”, “соёлын биет өвийг эзэмшигч, өмчлөгчийн эрх, үүрэг”, “соёлын өвийг сэргээн засварлахад идэвх санаачилгатай ажилласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах” зэрэг соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллага, түүний үйл ажиллагаатай холбоотой зүйл, заалтуудыг оруулжээ (Сүхбаатар, Отгонсүрэн 2019, 18).

Түүх, соёлын дурсгалт барилгыг “хамгаалах”, “хэсэгчлэн сэргээн засварлах”, “бүтнээр нь сэргээн засварлах” гэсэн үндсэн гурван аргаар сэргээн засварлах бөгөөд “эх төрх, хийц бүтээцийг хадгалж үлдээх”, “аюулгүй, удаан хугацаанд хадгалах нөхцөлийг хангах” зэрэг үндсэн зарчмыг баримтлах зохицуулалттай байдаг.

Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлахтай холбоотой төрийн эрх бүхий байгууллагын чиг үүргийн талаар, соёлын өв тэр дундаа түүх, соёлын дурсгалт барилга нь тухайн улс үндэстний төрийн бодлого, оюун ухаан, хөрөнгө, хүч хөдөлмөрөөр бүтсэн түүхэн цаг үед дахин давтагдашгүй хийц, шийдлүүдтэй байдаг тул түүнийг сэргээн засварлах ажил зөвшөөрөл, хяналтын дор хийгдэх зохицуулалттай байдаг. Өөрөөр хэлбэл, төрийн бодлого шийдвэр, эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлахыг хориглодог.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т зааснаар

Засгийн газар нь “соёлын өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх” чиг үүрэгтэй. Энэ хүрээнд Засгийн газрын 2014 оны 238 дугаар тогтоолоор “Соёлын баримтат өвийг хамгаалах хөтөлбөр”-ийг баталсан боловч энэ нь соёлын өвийн бүх төрөл, хэлбэр, тэр дундаа түүх, соёлын дурсгалт барилгад хамаарахгүй байна.

Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлахын тулд зохих судалгаа, шинжилгээний ажил хийж, ажлын даалгаврыг нарийн тодорхой боловсруулах шаардлагатай байдаг. Тухайн барилгын хийц загвар, бүтээц, орц материал, ашиглалт талаас нь иж бүрэн судалж, түүний үр дүнг сэргээн засварлалтын ажлын даалгаварт тусгах нь нэн чухал боловч зөвлөмж өгөх эрх бүхий мэргэжлийн буюу судалгааны байгууллага хомс, хууль эрх зүйн зохицуулалт байхгүй тул дурсгалт барилгын сэргээн засварлалтын суурь судалгаа дутмаг байна. Үүнээс шалтгаалж сэргээн засварлах объектын ажлын зураг, төсвийн тооцоолол тэр бүр оновчтой гардаггүй. Ингэснээр гүйцэтгэлийн явцад нэмэлтээр хийх буюу төсөвт тусгагдаагүй ажлууд олон тоогоор гарч, тэдгээрийг санхүүжүүлэх эх үүсвэр, хамгийн гол нь тохирох материал бэлдцийг олох шаардлагатай болдог нь захиалагч болон гүйцэтгэгч талуудын аль алинд нь ихээхэн хүндрэл учруулдаг тулгамдсан асуудал юм. Ажлын даалгаврыг үндэслэн сэргээн засварлах ажлын зураг төслийг боловсруулах ба энэхүү зураг төсөлд Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөл ажиллан, дэмжих бол саналаа Соёлын асуудал эрхэлсэн сайдад уламжилдаг. Сайд соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрлийг “Соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөл”-ийн дүгнэлтийг үндэслэж олгоно. Мөн Соёлын сайд “Соёлын биет өвийг сэргээн засварлах мэргэжлийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүн болон ажиллах журмыг батална хэмээн 2014 оны “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-д заасан байдаг. Харин 2017 онд Соёлын өвийн үндэсний төвийн дэргэд “Архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажилд хяналт, дүн шинжилгээ хийх шинжээчийн зөвлөл” байгуулагдан ажилласан.

Соёлын сайдын 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/61 дугаар тушаалаар нэгдүгээр хавсралтаар “Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”, хоёрдугаар хавсралтаар “Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн”, гуравдугаар хавсралтаар “Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам” зэргийг баталжээ. Уг журамд мэргэжлийн зөвлөл нь Соёлын биет өвийг сэргээн засварлах ажлыг төлөвлөх, зохицуулах бодлогын хувилбар боловсруулахад дэмжлэг үзүүлэх; Соёлын биет өвийг сэргээн засварлах зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хэлэлцэж санал дүгнэлт гаргах; Соёлын биет өвийг сэргээн засварлах ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх; Соёлын биет өвийг сэргээн засварласан ажлын тайланг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах; Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах ажлын даалгавар, зураг төслийг хянаж зөвлөмж өгөх; Соёлын биет өвийг сэргээн засварлах байгууллагад эрх олгох асуудлыг хэлэлцэж санал дүгнэлт гаргах; Соёлын биет өвийг сэргээн засварлах үйл ажиллагаанд хяналт

тавих, зөвлөмж өгөх чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

2017 онд Соёлын өвийн төвийг “Үндэсний төв” болгон зохион байгуулж, үйл ажиллагааг нь өргөжүүлсэн бөгөөд үүний бүрэлдэхүүнд:

- Эртний түүхэн дурсгалт барилга болон эртний хот суурины үлдэгдэл, туурь зэрэг архитектурын өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалтын ажлын зураг төсөл, эвдрэл, гэмтлийн судалгаа, төсөв, сэргээн засварлах эрх бүхий байгууллагын ажлын төлөвлөлт, гүйцэтгэл зэрэгт хяналт тавих, зөвлөн туслах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиг үүрэгтэй “Түүхэн дурсгалт барилга архитектурын дурсгалыг хамгаалах газар”;
- Дурсгалт барилгын сэргээн засварлалтын ажилд холбогдох, археологийн олдвор, хөшөө чулуун дурсгал, сүм хийд, түүхэн дурсгалт уран барилгын өнгө будаг зэрэг органик болон органик бус эд өлгийн эвдрэл гэмтлийг тодорхойлох, музейн үзмэрийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах арга зүйн технологийг боловсруулж, соёлын өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааны олон талт суурь судалгаанд суурилсан мэдээллийн сан үүсгэх замаар соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын шинжлэх ухааныг практикт нэвтрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх “Хадгалалт хамгаалалт, технологи судалгааны газар”;
- Цагийн эрхээр эвдэрч гэмтсэн мод, чулуу, металл, даавуу, цаас, арьс шир, яс, шавар, шаазан зэрэг төрөл бүрийн материалаар хийгдсэн үзмэр, эд өлгийн зүйл болон байгалийн хад чулуун хөшөө, үл хөдлөх дурсгалыг шинжлэх ухааны судалгаанд үндэслэн, урлахуйн ухааны уламжлалт мэдлэг, арга ухааныг орчин үеийн дэвшилтэт арга технологитой хослуулан сэргээн засварлах үйл ажиллагааг гүйцэтгэх “Сэргээн засварлах газар”;
- Үндэсний хэмжээнд соёлын өвд сөрөг нөлөөлөх байгалийн гамшиг эрсдэл болон нийгмийн сөрөг хүчин зүйлийн эрсдэлийн төрөлжсөн судалгаа, үнэлгээ, соёлын өвийг авран хамгаалах арга хэмжээг шуурхай зохион байгуулах, соёлын өвийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах “Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газар” тус тус байгуулагдан ажиллаж байна.

Соёл урлагийн газар нь төрөөс түүх, соёлын дурсгалт барилгыг хамгаалах талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, үзлэг, тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд явуулж, үр дүнг Засгийн газарт тайлагнах; Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэх ажлыг зохион байгуулах, бүртгэгдсэн өвийг хадгалж хамгаалах арга хэмжээ авах; Түүх соёлын дурсгалт барилгыг бүтээгдэхүүний загварт оруулж, зах зээлд нийлүүлэх эрх авсан байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих; Түүх, соёлын дурсгалт барилгад устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа бол сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж, улс, орон нутгийн төсвийн болон хандивын хөрөнгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа түүх, соёлын дурсгалт барилгыг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээ авах бүрэн эрхтэй. Аймаг, нийслэлийн засаг

дарга соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын болон дээд шатны байгууллагын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ соёлын өвд эрсдэл учруулахуйц аливаа үйл ажиллагааг таслан зогсоож, хуульд заасны дагуу арга хэмжээ авах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх бол сум дүүргийн засаг дарга соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах үүрэгтэй байдаг.

Дурсгалт барилгыг сэргээн засварлах үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах үйл ажиллагааг эрхлэх мэргэжлийн байгууллага нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай. 2022 оны байдлаар түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалтын зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий 24, түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлалт, угсралт өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авсан 70 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Хэдийгээр манай оронд сэргээн засварлах тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагууд цөөнгүй байгаа боловч тэдгээрт дурсгалт барилга байгууламжийг сэргээн засварлах чиглэлээр тухайлан мэргэшсэн чадварлаг мэргэжилтэн ихээхэн дутмаг байдгийн зэрэгцээ бодит объект дээр сэргээн засварлалтыг хэрэгжүүлэх нөхцөлд уг ажлыг олон нийтийн зүгээс ойлгохгүй эсэргүүцэх, эсвэл зориудаар буруу ойлголт өгөх зэрэг зохисгүй үйлдлүүд түгээмэл гаргадаг нь сэргээн засварлалтын ажлыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэхэд ихээхэн хүндрэл учруулж, саад тотгор болох тохиолдол цөөнгүй байна (Чойжин ламын сүм музей 2018, 25).

Түүх, соёлын дурсгалт барилгыг улсын болон орон нутгийн музей хариуцаж эзэмших чиг үүрэгтэй байдаг боловч сэргээн засварлах үйл ажиллагаанд оролцох хууль, эрх зүйн зохицуулалт байдаггүй. Тухайлбал, эзэмшигч буюу музейд түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах төсөв, сэргээн засварлагчийн орон тоо байдаггүй болно. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.6-д зааснаар “өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр соёлын биет өвийг сэргээн засварлахгүй байх” үүргийг хүлээлгэсэн байдаг ба үүнийг зөрчвөл “Зөрчлийн тухай хууль”-д зааснаар торгох шийтгэлтэй.

Дурсгалт барилгын сэргээн засварлах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэхээс гадна Монгол Улсын болон гадаадын иргэн, олон улсын байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламжаар санхүүжүүлж болохоор хуульд заасан боловч үүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин дутмаг байна. Эрх зүйн хувьд дурсгалт барилгыг сэргээн засварлах бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаанд эзэмшигчийн оролцоо сул байгаа нь өнөөгийн практикт төдийлөн нийцэхгүй байгаа юм.

Дурсгалт барилгыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална гэж хуульчилсан боловч энэхүү журам өнөөдрийг хүртэл батлагдаагүй байна.

Дурсгалт барилгыг сэргээн засварлахад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль”-ийн дагуу тендер зарлаж,

бага үнийн аргыг үндэслэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулдаг. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийг төсөвт өртөгтөө тохируулан хямд үнэтэй материал ашиглан хийж болох бөгөөд энэ нь сэргээн засварлах ажил стандарт шаардлага хангахгүй байх, чанаргүй болох зэрэг сөрөг үр дагавруудыг дагуулах эрсдэлтэй юм. Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварласан ажлын дэлгэрэнгүй тайланг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан болон архивд шилжүүлдэг.

Дэлхий дахинд түүх, соёлын дурсгалт зүйлсийн сэргээн засварлалтын хүрээнд олон асуудлууд тулгарч ирсэн байдаг. Иймд тэдгээрийн шалтгааныг ул суурьтай судалж, тогтоон, оновчтой шийдвэрлэх үүднээс багагүй хүч чармайлтыг гаргаж иржээ. Тухайлбал, 1964 онд Олон улсын түүхэн хөшөө дурсгалын архитектор, мэргэжилтний II Конгрессыг Венец хотноо хуралдуулж “Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах, сэргээн засварлах олон улсын дүрэм”⁴-ийг хэлэлцэж баталсан бөгөөд энэхүү дүрмийг хэрэгжүүлэхийн тулд 1965 онд ЮНЕСКО-гийн дэргэд Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах Олон улсын зөвлөл (ICOMOS⁵) –ийг байгуулжээ.

Өнөөгийн байдлаар олон улсын хэмжээнд ЮНЕСКО-ийн зөвлөл байгууллага болох ИКОМОС-ийн Ерөнхий чуулганаар баталсан 18 Харти, 17 Тунхаглал болон тогтоол, ИКОМОС-ийн Үндэсний зөвлөлөөр баталсан 7 Харти, 5 Олон улсын стандартыг дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд соёлын өвийг хамгаалах, бүртгэх, судалгаа хийх, сэргээн засварлах зэрэг үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна (Оюунбилэг 2019, 10).

Монгол Улсын Соёлын яам, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссоос “Хөшөө дурсгал, дурсгалт газрыг хадгалж хамгаалах Олон улсын Харти” (1964), “Хөшөө дурсгал, бүлэг барилга, дурсгалт газруудыг бүртгэх ИКОМОС-ийн зарчим” (1996), болон “Соёлын өвийн эх байдлыг хадгалах Нарагийн баримт бичиг” (1994) зэргийг албан ёсоор орчуулан мөрдөж байна. Гэвч энэ хүрээнд олон улсын эрх зүйн зохицуулалтын өөр бусад олон баримт бичиг байгаа бөгөөд манай улсын тухайд ЮНЕСКО-ийн гишүүн, “Байгалийн болон соёлын өвийг хамгаалах конвенци”-д нэгдэн орсон орны хувьд албан ёсоор орчуулагдаагүй байгаа бусад холбогдох баримт бичгийг дурсгалт барилгыг сэргээн засварлах ажилд мөрдөх ёстой юм.

2020-2021 онуудад хэрэгжүүлсэн Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка), Монгол Улсын Засгийн газар, Барилга, Хот байгуулалтын яамны хамтран хэрэгжүүлсэн “Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл”-ийн хүрээнд барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэртэй байдал, аюулгүй байдалтай

⁴ “Венецийн Харти” гэж нэрлэх нь түгээмэл

⁵ ICOMOS нь дэлхийн өнцөг булан бүрт байгаа хөшөө дурсгал, дурсгалт газрын хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус олон улсын байгууллага бөгөөд түүний салбар хороо нь улс бүхэнд ажиллаж байна. Түүнээс гадна ICOMOS нь ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хороонд Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр санал болгож буй соёлын үнэт зүйлсийн шинж чанарыг үнэлэх, харьцуулсан судалгаа, техникийн судалгаа болон дурсгалт газрын хадгалалтын байдлын тайланг гаргадаг. ICOMOS-оос хөшөө дурсгал, дурсгалт газрыг хамгаалах, хадгалах, сэргээн засварлах талаар олон улсын хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд мөрдөх дүрэм, журам, зарчим зэргийг боловсруулан мөрдүүлдэг.

холбоотой одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, үүнээс түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн талаар тусгайлан тусгасан эсэх талаарх судалгааг Барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэртэй байдал, аюулгүй байдалтай холбоотой заалтууд болон Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн талаарх зохицуулалт гэж ангилан авч үзсэн байдаг.

Хэлэлцүүлэг

Энэхүү судалгаанаас үзэхэд өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах хууль эрх зүйн баримт бичгүүдэд түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна. Эдгээр нь:

- Барилгын тухай хууль, 2016 он
- Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017 он
- Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, 2015 он
- “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм”, БНБД 22.01.01*/2006/ 2013, Барилга хот байгуулалтын сайдын 2013 оны 106 тоот тушаал;
- “Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм, дүрэм”, БНБД 22-04-16, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 198 тоот тушаал;
- “Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар”, БД-31-102-00
- “Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар”, БД-31- 101-00,
- “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 217 тоот тушаал;
- “Барилгын дүрэм”, БД 22-106-18, БХБ-ын Сайдын 2018 оны 185 тоот тушаал;
- “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам”⁶ БСШУ-ын сайд, Дэд бүтцийн сайдын хамтарсан 183/111 тоот тушаал, 2004.05.24;
- “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам”, Засгийн газрын 2018.06.18-ны 184 тоот тогтоол зэрэг болно.

Харин дурсгалт барилгатай холбоотой зүйл заалтууд дараах хууль эрх зүйн баримт бичгүүдэд орсон байна. Тухайлбал:

- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль-21.5. *Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж, тэдгээрийн ашиглалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна (хотын захирагч);*
- Хот байгуулалтын тухай хууль- 23.1. *Дараах бүсэд хэрэгжүүлэх хот байгуулалтын үйл ажиллагаанд хязгаарлалт тогтооно: 23.1.1. түүх, соёлын дурсгалт барилга байгууламж бүхий газар нутаг болон тусгай хамгаалалттай, 12.4.1... түүх, соёлын дурсгалт байгууламж,*

⁶ 2016 онд Барилгын тухай хууль шинээр батлагдсанаар холбогдох норм, дүрмүүд шинэчлэгдсэн.

- архитектур-хот байгуулалтын шаардлага, экологийн болон эрүүл ахуйн таатай нөхцөлийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байх;*
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль (1996.04.11)- 13.1.7. *улсын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батлах 47.2. Соёлын биет өвийг сэргээн засварлах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварлах журмыг соёлын болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. 13.1.12. түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс тогтоох;*⁷
 - Соёлын тухай хууль- 2. “Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь хариллах өөр зориулалтаар бүхэлд нь ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно”.
 - ЗГ-ын 2007 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”-т, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлахад шаардагдах нийт хөрөнгө 13198.0 сая төгрөг зарцуулна⁸;
 - Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаал 2000 оны 94 дүгээр тушаалаар 3 БД баталсан. 1.“Орон сууц, иргэний ба үйлдвэрийн барилга байгууламжийн газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх, судалгаа явуулах, даацын үндсэн бүтээцийг хүчитгэх, паспортжуулах заавар” (БД-31-103-00)-т 2.5. *Түүхийн хөшөө дурсгалд тооцогддог барилга байгууламжийг задлах болон судлахдаа хөшөө дурсгалыг хамгаалах улсын холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай*⁹;
 - Барилга, хот байгуулалтын сайдын 2018.12.31-ний 218 тоот тушаалаар баталсан “Барилга байгууламжийн түвэгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”- 2 дахь хэсэгт *Төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга төрөлд оруулан Өндөр төвөгшилтэй барилга байгууламж ангилалд Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийн сэргээн засварлах;* - *Музей, үзэсгэлэнгийн барилга байгууламж;* - *Сүм, хийдийн барилга байгууламж;*

⁷ БСШУ-ны сайд, Дэд бүтцийн сайдын 2004 оны 183/111 дүгээр хамтарсан тушаалаар “Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах ажил гүйцэтгэх журам” батлагдсан. Гэвч 2016 онд Барилгын тухай хууль шинээр батлагдсанаар холбогдох норм, дүрмүүд шинэчлэгдсэн.

⁸ Хөтөлбөрийн заалтаас үзэхэд Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг сэргээн засварлах, бэхжүүлэх хамгаалах, хэв дардас, хуулбар хийх, унаган газраас нь зөөж хадгалах, сургалт сурталчилгааны ажил гэх мэт арга хэмжээ тус бүрийг зарцуулах хөрөнгийн хамт төлөвлөсөн. Үүнээс: Бэхжүүлж хамгаалах дурсгалын жагсаалтад буган чулуу, хөшөө, балгас, тууриуд орсон байсан. Энэ хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дууссан ч зарцуулсан хөрөнгө, бий болсон үр дүнг харьцуулж үр нөлөөг нь өнөөдөр үнэлэх боломжтой. Үндэсний хөтөлбөрийн үр дүн, тайлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй байна. Соёлын өвийг судлах, хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтнийг 2008-2010 оны хооронд 13 хүнийг 400 сая төгрөгөөр бэлтгэхээр тусгасан.

⁹ Модон хучилт, дээвэртэй барилгын даацын бүтээцийг судлах талаар заасан боловч түүхий тоосготой түүх, соёлын дурсгалт барилгуудын талаар дурдагдаагүй.

- Шадар сайдын 2017.08.17-ны 78 тоот тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам”- зохицуулалт хамаарна.

Дээрхээс үзэхэд манай холбогдох хууль тогтоомжуудад түүх, соёлын дурсгалт барилга байгууламжтай холбоотой зарим ерөнхий заалтууд орсон боловч эдгээрийг сэргээн засварлах, хүчитгэх, бэхжүүлэх зохицуулалт хангалттай бүрэн гүйцэд биш гэж дүгнэж болохоор байна.

Дүгнэлт

Энэхүү судалгаанаас дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

1. Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах талаар засаг төрөөс зохих арга хэмжээг авч, хуулиудыг тухай бүр батлан гаргаж байсны зэрэгцээ 1998, 2007 онуудад Засгийн газрын тогтоолоор “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”-ийг баталж, 1999-2005, 2008-2015 онуудад хэрэгжүүлсэн нь зохих үр дүнгээ өгсөн бөгөөд эдүгээ хэрэгжих хугацаа нь дуусгавар болсон байна.
2. Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах талаар нэгдсэн бодлого, төлөвлөгөөгүй байх нь байгалийн болон хүний хүчин зүйлээс хамааралтай олон эрсдэлийг бий болгох тодорхой тул “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөр”-ийг баталж, цаашид тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал,
 - Монгол орны эрс тэс уур амьсгалд зохицсон судалгааны арга зүй болон консервацийн шинжлэх ухаанд суурилсан, системтэй, цогц үйл ажиллагаагаар түүх, соёлын дурсгалт уран барилгын сэргээн засварлалтын ажлын судалгаа, төлөвлөгөөг баглан хэрэгжүүлэх;
 - Дурсгалт барилгыг сэргээн засварлах эрх бүхий байгууллагуудыг чанаржуулах, шинээр бий болгох, хүний нөөцийг чадавхжуулах;
 - Дурсгалт барилгын сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, сэргээн засварлалтын ажлыг гүйцэтгэх хугацааг эрдэмтэн, судлаачдын боловсруулсан зөвлөмж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх;
 - Музейн үйл ажиллагаа явуулж буй түүх, соёлын дурсгалт барилга, цогцолборын хамгаалалтын бүсийг баталгаажуулан кадастрын зураг, гэрчилгээтэй болох;
3. Сэргээн засварлах ажилд эзэмшигч байгууллагын үүрэг, оролцоог хязгаарласан эрх зүйн зохицуулалт үйлчилж байгаа тул үүнийг эргэн харж, тухайн байгууллагын үр дүнтэй оролцоог бий болгосон зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.
4. Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах ажлын гүйцэтгэгчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д заасан журмын дагуу бага үнийн аргаар шалгаруулж байгаа нь гүйцэтгэсэн ажлын үр дүнд нөлөөлж болзошгүй тул сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх мэргэжлийн байгууллагын туршлага,

- мэдлэг ур чадварыг үндэслэн шууд гэрээгээр сонгох боломжийг тусгах талаар судлан үзэх нь зүйтэй.
5. Төрийн эрх бүхий байгууллагууд Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан холбогдох дүрэм, журмыг өнөөг хүртэл батлан гаргаагүй байгаа нь түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Тиймээс Соёлын өвийг хамгаалах хуульд заасан дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцүүлэн цаг алдалгүй батлан гаргах нь тулгамдсан асуудал болоод байна.
 6. Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах үйл ажиллагаа шинжлэх ухаан, технологийн өнөөгийн түвшинд хүрээгүй, материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчин, эрдэм шинжилгээ, судалгааны ажил дутмаг байгаагийн улмаас уг үйл ажиллагааны үр дүн технологи, чанарын шаардлагад хүрч чадахгүй байна. Тиймээс эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тохирох сайн технологийг бий болгох, нутагшуулахад анхаарч төрөөс зохих бодлого хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ашигласан материалын жагсаалт

- Монгол Улсын Засгийн газар Барилга, хот байгуулалтын яам-Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Жайка). 2021. *Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл*. <https://mcud.gov.mn/resource/mcud/File/2021/06/15/oyk07doxmgxrtusg/2021-04-28%20%D0%A2%D3%A8%D0%93%D0%A1%D0%93%D3%A8%D0%9B%D0%98%D0%99%D0%9D%20%D0%A2%D0%90%D0%99%D0%9B%D0%90%D0%9D.pdf>. 2024.03.01
- Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn>
- Оюунбилэг Зундуй. 2019. “Дурсгалт барилгын сэргээн засварлалт.” *Дурсгалт барилгын сэргээн засварлалт: тулгамдаж буй асуудлууд*, Ред. Нинжбадгар Зангад, Отгонсүрэн Дугарсүрэн. Улаанбаатар.
- Сүхбаатар, З., Отгонсүрэн, Д., 2019. “Түүх, соёлын дурсгалт барилгыг сэргээн засварлах үйл ажиллагааны эрх зүйн орчин.” *Дурсгалт барилгын сэргээн засварлалт: тулгамдаж буй асуудлууд*, Ред. Нинжбадгар Зангад, Отгонсүрэн Дугарсүрэн. Улаанбаатар.
- Чойжин ламын сүм музей. 2018. *Чойжин ламын дурсгалт барилгын сэргээн засварлалт (1940-2018)*. *Баримт бичгийн эмхэтгэл*, Ред. Отгонсүрэн Дугарсүрэн, Улаанбаатар: Адмон.